



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/01-02.

Дархан сум

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 41.2.3 дахь хэсэг, Сангийн сайдын “Хөрөнгө гаргах” тухай 243 тоот тушаалыг тус тус үндэслэн Тушаах нь:

1. Орон нутагт шинээр байгуулагдсан соёл, урлагийн нэгжид нэн шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулах 15,000,000 /Арван таван сая/ төгрөгийг багаж, техник хэрэгслийн зардлаас гаргахыг Соёл, урлагийн газрын Нягтлан бодогч /Т.Алтанцэцэг/-д зөвшөөрсүгэй.
2. Батлагдсан төсвийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зардлын тооцоо гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт бүрдүүлэхийг Нярав /Б.Долгормаа/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллах, тайлагнахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ